



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/133

Номгон

“Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл”-ийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай” хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий “Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслүүдтэй уялдуулан сумын түвшинд хэрэгжилтийг хангах орон тооны бус салбар зөвлөлийг байгуулж Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 04 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтад заасан дүрмийг хэрэгжүүлэн ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Аймаг, сумын салбар зөвлөлийн үйл ажиллагааг уялдуулан удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн дэд дарга (Г.Энхбаяр)-д үүрэг болгосугай.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Г.Төртогтох)-т үүрэг болгосугай.

5.“Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/169 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

1210335

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын
23-ны өдрийн А/133 дугаар захирамжийн хавсралт



**“ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛТИЙН
БҮРЭЛДЭХҮҮН**

Дэд тэргүүн: Нийгмийн салбар хариуцсан Засаг даргын орлогч

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн
дарга

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн
салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Залуучуудын холбооны тэргүүн

Аймгийн Нийгмийн Ардчилал Монголын Залуучуудын холбооны тэргүүн

Аймгийн Ардчилсан Монголын залуучуудын холбооны тэргүүн

Баянхонгор аймгийн Үүрэгтэй залуус Төрийн бус байгууллагын тэргүүн

Хүний эрхийн үндэсний комиссын Баянхонгор аймаг дахь референт

/зөвшилцснөөр/

Нарийн бичгийн дарга: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

_____оОо_____